




САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО



**ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН  
2017 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН ТОЙМ**



**АГУУЛГА**

<b>1. ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД.....</b>	<b>3</b>
1.1. Зах зээлийн үнэлгээ.....	3
1.2. Зах зээлийн үнэлгээ (ЗЗҮ)-ний дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-д эзлэх хувь, хөрвөх чадварын түвшин.....	4
1.3. Үнэт цаасны зах зээлийн индексүүд.....	5
<b>2. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ОРОЛЦОГЧИД.....</b>	<b>5</b>
2.1. Хувьцаат компаниуд.....	5
2.2. Зохицуулалттай этгээдүүд.....	6
<b>3. ЗАХ ЗЭЭЛ ДЭХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ .....</b>	<b>8</b>
3.1. Хувьцааны арилжаа.....	9
3.2. Засгийн газрын үнэт цаас /ЗГҮЦ/-ны арилжаа.....	9
3.3. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа .....	10
3.4. Хөдөө аж ахуйн биржийн арилжаа.....	10
<b>4. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТ .....</b>	<b>10</b>
4.1. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үзүүлэлтүүд.....	11

## ЗУРАГ

Зураг 1. Зах зээлийн үнэлгээ /тэрбум төгрөг/ .....	3
Зураг 2. Хөрвөх чадварын түвшин.....	4
Зураг 3. ТОП-20 индекс .....	5
Зураг 4. Хувьцаат компанийн тоо .....	5
Зураг 5. Мэргэжлийн оролцогчдын тоо.....	8
Зураг 6. Хувьцааны арилжаа /тэрбум төгрөг/ .....	9
Зураг 7. Нийт арилжааны үнийн дүнд эзлэх хувь .....	9
Зураг 8. ҮЦТХТ-д нээгдсэн дансны тоо.....	11
Зураг 9. Хөрөнгө оруулагчдын арилжаанд эзлэх хувь.....	11

## ХҮСНЭГТ

Хүснэгт 1. Зах зээлийн үнэлгээ өндөр 30 компани .....	4
Хүснэгт 2. Хувьцаат компанийн өмчийн хэлбэр, тоо .....	6
Хүснэгт 3. Хувьцаат компанийн хувьцааны бүтэц .....	6
Хүснэгт 4. Зохицуулалттай этгээдийн тоо .....	6
Хүснэгт 5. Нийт хөрөнгө /тэрбум төгрөг/ .....	7
Хүснэгт 6. Нийт орлого /тэрбум төгрөг/ .....	7
Хүснэгт 7. Үнэт цаасны арилжааны үзүүлэлт .....	8
Хүснэгт 8. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас /тэрбум төгрөг/ .....	10
Хүснэгт 9. ХААБ-ийн арилжааны үнийн дүн, хэмжээ .....	10

## ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ


Үнэт цаасны зах зээлийн 2017 оны 3 дугаар улирлын тоймоор салбарын хөгжлийг илэрхийлэгч үзүүлэлтүүд болох зах зээлийн үнэлгээ, хөрвөх чадвар, хувьцааны индекс, бүртгэлтэй компанийн тоог өмнөх оны мөн үетэй харьцуулан авч үзлээ. Түүнчлэн үнэт цаасны зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг илэрхийлэгч үзүүлэлтүүд болон дэд бүтцийн төлбөр тооцоо, хадгаламжийн үзүүлэлтүүд, үнэт цаасны арилжааны дүн, зохицуулалттай этгээд болон хөрөнгө оруулагчдын үнэт цаасны арилжаанд эзлэх оролцоогхураангуй байдлаар харуулав.

### 1. ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

#### 1.1. Зах зээлийн үнэлгээ

Үнэт цаасны зах зээлийн багтаамж, түүний эдийн засгийн өсөлтийг дунд болон урт хугацаанд дэмжигч гол үзүүлэлт нь үнэт цаасны зах зээлийн үнэлгээ бөгөөд энэхүү үзүүлэлтийн өсөлт, бууралт нь үнэт цаасны зах зээлийн хөгжлийн түвшинг, улмаар эдийн засгийн хөгжилд хэрхэн нөлөө үзүүлж байгааг илэрхийлэгч үндсэн индикатор болдог.

Зураг 1. Зах зээлийн үнэлгээ /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2017 оны 3 дугаар улирлын байдлаар үнэт цаасны зах зээлийн үнэлгээ 2083.1 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 695.4 тэрбум төгрөг буюу 50.1 хувиар өссөн үзүүлэлт юм. Тайлант хугацаанд нийт 95 компанийн үнэт цаас арилжигдсанаас өмнөх оны мөн үетэй харьцуулахад харьцуулахад 50 компанийн үнэт цаасны ханш өсч, 42 компанийн үнэт цаасны ханш буурч, 3 компанийн үнэт цаасны ханш тогтмол байсан. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад энэхүү өсөлтөд ТОП-20 индексэд багтдаг нэр бүхий таван хувьцааны ханш 385.13, 99.67, 79.47, 58.46 хувиар тус тус өссөн нь голлох нөлөөг үзүүлсэн.

Нийт зах зээлийн үнэлгээний 92.8 хувийг 30 компани бүрдүүлсэн бөгөөд эдгээр компаниудын ихэнх нь уул уурхай, аж үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа нь уул уурхайн салбарын өсөлт, бууралттай холбоотойгоор дотоодын үнэт цаасны зах зээлийн үнэлгээнд шууд нөлөө үзүүлж байна.

Хүснэгт 1. Зах зээлийн үнэлгээ өндөр 30 компани


№	Үнэт цаасны нэр	Үнэлгээ /тэрбум төгрөг/	№	Үнэт цаасны нэр	Үнэлгээ /тэрбум төгрөг/
1	ТАВАН ТОЛГОЙ	489.8	16	БИДИСЕК	20.3
2	АПУ	468.3	17	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	18.8
3	МИК ХОЛДИНГ	228.4	18	БЭРХ УУЛ	15.2
4	ГОВЬ	136.4	19	БАЯНГОЛ ЗБ	15.2
5	УБ БҮК	78.8	20	МОН.ЦАХИЛГААНХОЛБОО	14.5
6	СҮҮ	57.9	21	АРИГ ГАЛ	13.8
7	БАГАНУУР	54.4	22	ТЕХНИКИМПОРТ	13.5
8	МОНГОЛ ШУУДАН ХК	37.6	23	МАТЕРИАЛИМПЕКС	13.0
9	ГУТАЛ	36.3	24	ГЕРМЕС ЦЕНТР	12.2
10	ШИВЭЭ ОВОО	33.5	25	АТАР ӨРГӨӨ	10.8
11	МОНГОЛ СЕКЬЮРИТИЕС	26.7	26	МАХИМПЕКС	10.6
12	ДАРХАН НЭХИЙ	26.0	27	СИЛИКАТ	8.3
13	ТАЛХ ЧИХЭР	24.6	28	ХӨХ ГАН	8.2
14	ШАРЫН ГОЛ	24.3	29	АДУУНЧУЛУУН	7.9
15	ТАХЬ КО	21.4	30	ЕВРОАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ	6.6

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

1.2. Зах зээлийн үнэлгээ (ЗЗҮ)-ний дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-д эзлэх хувь, хөрвөх чадварын түвшин

2017 оны 3 дугаар улирлын байдлаар ЗЗҮ-г 2016 оны жилийн эцсийн үйлдвэрлэлийн аргаар тооцсон нэрлэсэн ДНБ-ны хэмжээтэй харьцуулахад 8.7 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 2.7 хувиар өссөн үзүүлэлт юм. Харин тайлант хугацааны зах зээлийн үнэлгээнд хувьцааны арилжааны үнийн дүнг харьцуулан хөрвөх чадварыг тооцсон дүн 0.296 нэгж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.04 нэгжээр буурсан байна.

Зураг 2. Хөрвөх чадварын түвшин



\*2016 оны жилийн эцсийн нэрлэсэн ДНБ-д харьцуулсан дүн

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Манай улсын хувьд хувьцааны хөрвөх чадварын түвшин бусад хөгжиж буй орнуудтай харьцуулахад доогуур түвшинд байгаа ба үүнд хөрөнгийн биржид бүртгэлтэй


компаниудын хувьцаа хэт төвлөрсөн, компанийн засаглал, санхүүгийн тайлагнал, мэдээллийн ил тод байдал хангалтгүй, хангалттай хэмжээний шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ байхгүй, олон нийтийн хөрөнгө оруулалт, хувьцааны талаарх мэдлэг, мэдээлэл дутмаг зэрэг хүчин зүйлс гол нөлөөг үзүүлж байна.

### 1.3. Үнэт цаасны зах зээлийн индексүүд

Тайлант хугацаанд ТОП-20 индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6959.32 нэгжээр буюу 60.9 хувиар өсч 18392.48 нэгж болсон бөгөөд нидексийн дээд үзүүлэлт 18686.91 нэгж, доод үзүүлэлт 12700.93 нэгж, дундаж үзүүлэлт 15334.86 нэгж байна.

Тайлант хугацаанд MSE ALL индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 244.86 нэгжээр буюу 29.9 хувиар өсч 1064.31 нэгж болсон бөгөөд индексийн дээд үзүүлэлт 1070.24 нэгж, доод үзүүлэлт 849.02 нэгж, дундаж үзүүлэлт 945.79 нэгж байна.

Зураг 3.ТОП-20 индекс




Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ХК

## 2. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ОРОЛЦОГЧИД

### 2.1. Хувьцаат компаниуд

Тайлант хугацаанд Хорооны үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлд нийт 300 компани бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж байна.

Зураг 4. Хувьцаат компанийн тоо



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

**Хүснэгт 2. Хувьцаат компанийн өмчийн хэлбэр, тоо**

Үнэт цаас гаргагчийн өмчийн бүтэц	“ҮЦТХТ” ХХК	“Монголын хөрөнгийн бирж” ХК	СЗХ
Төрийн өмчит	21	19	31
Төрийн өмчийн оролцоотой	22	15	19
Хувийн өмчит	269	176	250
<b>Нийт</b>	<b>312</b>	<b>210</b>	<b>300</b>

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

**Хүснэгт 3. Хувьцаат компанийн хувьцааны бүтэц**

Үнэт цаас гаргагчийн ангилал	2015 он	2016 он	2017.III
Төрийн мэдлийн бус хувьцаа	2,809,930	4,160,854	4,173,666
Төрийн мэдлийн хувьцаа	2,246,316	2,818	2,818,124
Орон нутгийн оролцоотой	29,046	29,046	29,046
<b>Нийт</b>	<b>5,085,292</b>	<b>7,008,024</b>	<b>7,020,836</b>
Эрдэнэс Тавантолгой /Иргэн/	2,558,176	2,212,224	2,212,224
Эрдэнэс Тавантолгой /ААН/	5,139	5,203	7,065
Эрдэнэс Тавантолгой /Төр/	12,436,685	12,782,573	-
Эрдэнэс Тавантолгой /"Эрдэнэс Монгол" ХХК/	-	-	9,780,711
Эрдэнэс Тавантолгой /Арилжигдаагүй үлдэгдэл/	-	-	3,000,000
<b>Нийт</b>	<b>15,000,000</b>	<b>15,000,000</b>	<b>15,000,000</b>
Хаалттай ХК	172,753	174,958	224,450
<b>Нийт</b>	<b>172,753</b>	<b>174,958</b>	<b>224,450</b>

Эх сурвалж: “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК

**2.2. Зохицуулалттай этгээдүүд**

Тайлант хугацаанд 52 компани Хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд үнэт цаасны арилжаа эрхлэх 2, үнэт цаасны төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх 1, төвлөрсөн хадгаламжийн 1, кастодиан банкны үйлчилгээ үзүүлэх 3, хөрөнгө оруулалтын менежментийн 14 компани үйл ажиллагаа явуулж байгаа бол хөдөө аж ахуйн биржийн арилжаа, зуучлалын чиглэлээр арилжаа эрхлэх 1, бараа, түүхий эдийн арилжааны зуучлалын үйл ажиллагаа эрхлэх 17 этгээд тусгай зөвшөөрөлтэй байна. Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж буй зохицуулалттай этгээдүүдийг хүснэгтээр үзүүлбэл:

**Хүснэгт 4. Зохицуулалттай этгээдийн тоо**

№	Зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэгч	Оролцогчдын тоо
1	Үнэт цаасны арилжаа эрхлэх	2
2	Үнэт цаасны төлбөр тооцооны	1
3	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн	1
4	Хөрөнгө оруулалтын менежментийн	14
5	Кастодиан банк	3
	<b>Мэргэжлийн оролцогчид:</b>	<b>52</b>
6	Брокер	51
7	Дилер	48
8	Андеррайтер	22

9	Хөрөнгө оруулалтын зөвлөх	14
10	Хөрөнгө оруулалтын сан (хувийн)	8
<b>Нийт</b>		<b>81</b>
11	Хөдөө аж ахуйн түүхий эдийн арилжаа эрхлэх	1
12	Хөдөө аж ахуйн түүхий эдийн брокер	17
13	Аудитын компани	47
14	Үнэлгээний компани	21
15	Хуулийн компани	19

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

**Мэргэжлийн оролцогчдын өнөөгийн нөхцөл байдал:** 2017 оны 3 дугаар улирлын байдлаар Хороонд бүртгэлтэй 52 мэргэжлийн оролцогч байгаа бөгөөд өмнөх оны мөн үеийн (2016 оны III улиралд нийт 62 мэргэжлийн оролцогч байсан) тайлангийн үзүүлэлтүүдтэй харьцуулахад нийт хөрөнгө 18.4 тэрбум төгрөг буюу 25.8 хувиар өсөж 89.8 тэрбум төгрөг, үйл ажиллагааны орлого 2 тэрбум буюу 57 хувиар өсөж 5.5 тэрбум төгрөг, тайлант үеийн нийт цэвэр ашиг 2.5 тэрбум буюу 227 хувиар өсөж 1.4 тэрбум болж тус тус өссөн байна (Өмнөх оны мөн үед нийт 62 үнэт цаасны компаниуд үйл ажиллагаа явуулдаг байсан бөгөөд эдгээрийн хөрөнгө 71.4 тэрбум төгрөгтэй тэнцэж, нийт үйл ажиллагааны орлого 3.5 тэрбум төгрөг байсан бөгөөд тайлант үеийн цэвэр алдагдал 1.1 тэрбум төгрөгтэй тэнцэж байв).

**Хүснэгт 5. Нийт хөрөнгө /тэрбум төгрөг/**

№	Үндсэн үзүүлэлтүүд	2016.III	2017.III	Өсөлт/бууралт
1	Эргэлтийн хөрөнгийн дүн	50.63	70.50	39.3%
2	Эргэлтийн бус хөрөнгө	20.82	19.28	-7.4%
3	<b>Нийт актив</b>	<b>71.44</b>	<b>89.78</b>	25.7%
4	Өр төлбөр	11.65	21.68	86.1%
5	Эздийн өмч	59.80	68.11	13.9%
6	<b>Нийт пассив</b>	<b>71.44</b>	<b>89.78</b>	25.7%
Хувь нийлүүлсэн хөрөнгө		49.79	53.20	6.9%

Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

2017 оны 3 улирлын байдлаар нийт 52 компаниас нэр бүхий 15 компани нь ашигтай, 37 компани нь алдагдалтай ажилласан байна. Цаашид компаниудын санхүүгийн чадавхыг нэмэгдүүлэх, хөрөнгөжүүлэх, эдгээр компаниудыг хооронд нь нэгтгэх, нийлүүлэхийг бодлогоор дэмжиж, үйл ажиллагааны хувьд бие даасан, мэргэшсэн боловсон хүчинтэй, техник програм хангамжийн хувьд олон улсын түвшинд нийцсэн мэргэжлийн зуучлагчийн түвшинд хүргэх шаардлагатай тулгарч байна.

**Хүснэгт 6. Нийт орлого/тэрбум төгрөг/**


№	Орлогын хураангуй тайлан	2016.III	2016 он	2017.III
1	Үйл ажиллагааны орлого	3.46	5.49	5.51
2	Ногдол ашгийн орлого	0.44	0.49	0.77
3	Борлуулалт маркетингийн болон ерөнхий ба удирдлагын зардал	4.70	6.10	3.75
4	Ажиллагчдын цалингийн зардал	2.16	2.78	1.79
5	Албан татвар, төлбөр, хураамжийн зардал	0.65	0.85	0.63
6	Санхүүгийн зардал	0.25	0.59	0.74
7	Бусад зардал	0.04	0.08	0.03
8	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.33	0.64	-0.04
9	Бусад ашиг (алдагдал)	-1.36	-0.38	-1.29



10	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	1.00	1.13	1.69
11	Орлогын татварын зардал	0.09	0.12	0.27
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-1.09	1.02	1.42

Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

Зураг 5. Мэргэжлийн оролцогчдын тоо



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хууль тогтоомж, гэрээгээр хүлээсэн үүрэг, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангадаггүй 10 компанийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн бөгөөд 3 сарын хугацаанд гаргасан зөрчлийг арилгаж, Хороонд мэдэгдэх үүрэг өгөгдсөн. Энэ дагуу 3 дугаар улиралд өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж ажиллаагүй 9 компанийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.

Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох арга хэмжээ авсанаар зах зээлд оролцогч компаниудын тоо буурсан бөгөөд үүнийг дагаад хувьцааны үнэ ханшийг зохиомлоор өсгөх, бууруулах, зах зээлд худал мэдээлэл тараах зэрэг үйл ажиллагаа явуулах компаниудын тоо буурч манай улсын хөрөнгийн зах зээлд итгэх хөрөнгө оруулагчдын оролцоо, идэвх нэмэгдэхэд эерэг нөлөө үзүүлэх юм.

### 3. ЗАХ ЗЭЭЛ ДЭХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ

2017 оны 3 улиралд “Монголын хөрөнгийн бирж” ХК-аар дамжуулан нийт 208.5 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий арилжаа хийгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 86.3 хувиар өсчээ. Нийт арилжааны 3 хувийг хувьцаа, 1.5 хувийг компанийн бонд, 95.5 хувийг ЗГҮЦ-ны арилжаа тус тус эзэлсэн байна.

Хүснэгт 7. Үнэт цаасны арилжааны үзүүлэлт


Үнэт цаасны төрөл		Арилжигдсан тоо хэмжээ /сая ширхэг/	Арилжааны үнийн дүн/тэрбум төгрөг/
Хувьцаа	Анхдагч зах зээл	-	-
	Хоёрдогч зах зээл	10.2	6.2
ЗГҮЦ	Анхдагч зах зээл	1.7	169.5
	Хоёрдогч зах зээл	0.3034	29.6
Компанийн бонд	Хоёрдогч зах зээл	0.0324	3.2

Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ХК

### 3.1. Хувьцааны арилжаа

Тайлант хугацаанд нийт 60 удаагийн арилжаагаар 95 компанийн 10.2 сая ширхэг хувьцааг 6.2 тэрбум төгрөгөөр арилжсан байна. Нийт 95 компанийн үнэт цаас арилжигдсанаас өмнөх оны мөн үетэй харьцуулахад 50 компанийн үнэт цаасны ханш өсч, 42 компанийн үнэт цаасны ханш буурч, 3 компанийн үнэт цаасны ханш тогтмол байлаа. Идэвхтэй арилжигдсан 20 үнэт цаасны тоо ширхэг нь нийт арилжигдсан ширхэгийн 98.3 хувь, үнийн дүнгийн 95.4 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 6. Хувьцааны арилжаа /тэрбум төгрөг/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

### 3.2. Засгийн газрын үнэт цаас /ЗГҮЦ/-ны арилжаа

**Анхдагч зах зээлийн арилжаа:** Тайлант хугацаанд ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаа 16 удаа явагдаж, 12, 28, 39, 52, 104, 156 долоо хоногийн хугацаатай нийт 1.7 сая ширхэг үнэт цаасыг 169.5 тэрбум төгрөгөөр арилжсан байна.

**Хоёрдогч зах зээлийн арилжаа:** ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаагаар 493.6 мянган ширхэг үнэт цаасыг 29.6 тэрбум төгрөгөөр, компанийн бондын хоёрдогч зах зээлийн арилжаагаар 32.4 мянган ширхэг бондыг 3.2 тэрбум төгрөгөөр арилжсан байна. Нийт арилжааны үнийн дүнгийн 14.2%-ийг ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаа, 1.5%-ийг компанийн бондын арилжаа тус тус эзэлж байна.

Зураг 7. Нийт арилжааны үнийн дүнд эзлэх хувь



Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ХК

### 3.3. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа

“МИК ОССК” ХХК нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасны дагуу орон сууцны зээлээр баталгаажсан үнэт цаас гаргах хүрээнд тусгай зориулалтын компаниудыг үүсгэн байгуулж, СЗХ-ноос хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, хөрөнгө итгэмжлэн удирдах зөвшөөрөл аван ажиллаж байна.

#### Хүснэгт 8. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас /тэрбум төгрөг/

ХБҮЦ гаргагч	Нийт гаргасан үнэт цаас	"ҮЦТХТ" ХХК-д бүртгэгдсэн	Зээлдэгчийн тоо
“МИК активнэг ТЗК” ХХК	328.1	322.9	6,658
“МИК активхоёр ТЗК” ХХК	224.8	222.1	5,290
“МИК активгурав ТЗК” ХХК	328.5	324.6	6,593
“МИК активдөрөв ТЗК” ХХК	459.4	452.3	9,510
“МИК активтав ТЗК” ХХК	301.2	294.3	5,805
“МИК активзургаа ТЗК” ХХК	267.8	261.7	5,188
“МИК активдолоо ТЗК” ХХК	299.6	293.8	5,414
“МИК актив найм ТЗК” ХХК	189.8	186.3	3,291
“МИК актив ес ТЗК” ХХК	137.5	137.2	1,719
“МИК актив арав ТЗК” ХХК	103.0	96.3	1,585
“МИК актив арван нэг ТЗК” ХХК	70.9	67.5	1,135
“МИК актив арван хоёр ТЗК” ХХК	272.3	262.4	4,439
<b>Нийт</b>	<b>2,982.9</b>	<b>2,921.4</b>	<b>56,627</b>

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

### 3.4. Хөдөө аж ахуйн биржийн арилжаа

2017 оны 3 дугаар улирлын байдлаар ХААБ-ээр нийт 68.1 тэрбум төгрөгийн түүхий эд, материал арилжаалагдсан байна. Үүнд ямааны ноолуур 83.1%, хонины ноос 15.17%, тэмээний ноос 1.07%-ийг эзэлж байна.

#### Хүснэгт 9. ХААБ-ийн арилжааны үнийн дүн, хэмжээ

№	Барааны нэр	Арилжааны дүн /тэрбум төгрөг/	Эзлэх хувь /%/
1	Ямааны ноолуур	56.63	83.10
2	Хонины ноос	10.34	15.17
3	Тэмээний ноос	0.73	1.07
4	Хонины завод ноос	0.07	0.10
5	Ямааны завод ноос	0.38	0.56
	<b>Нийт</b>	<b>68.15</b>	<b>100</b>

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


## 4. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТ

“Монголын хөрөнгийн бирж” ХК-д хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш төвлөрсөн хадгаламжид өссөн дүнгээр нийт 893,646 данс, 140,882 холболтын данс нээгдсэн. Нийт дансыг бүтцээр нь үзвэл, 888,646 дотоодын иргэн, 1,994 гадаадын иргэн, 2,591 дотоодын аж ахуйн нэгж, 182 гадаадын аж ахуйн нэгжийн данс тус тус байна.

Тайлант хугацаанд үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид нийт 10,689 данс шинээр нээгдсэнээс 10,518 нь дотоодын иргэн, 95 нь гадаадын иргэн, 69 нь дотоодын аж ахуйн нэгж, 7 гадаадын аж ахуйн нэгжийн данс тус тус эзэлж байна.

2017 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар арилжааны бус хэлцэл болох өв залгамжлалын нийт 260 гүйлгээ хийгдэж, давхардсан тоогоор 287 ХК-ийн 760,979 ширхэг хувьцааны өмчлөх эрхийг, бэлэглэлээр 21 ХК-ийн 145,960 ширхэг хувьцааны өмчлөх эрхийг шилжүүлэх 79 гүйлгээ хийгдсэн.


**Зураг 8. ҮЦТХТ-д нээгдсэн дансны тоо**



Эх сурвалж: “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК

Тайлант хугацаанд “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн арилжааны үнийн дүнд гадаадын аж ахуйн нэгж болон иргэдийн эзлэх хувь 0.05 нэгж байгаа бол дотоодын аж ахуйн нэгж болон дотоодын иргэдийн эзлэх хувь 0.95 нэгж байна.

**Зураг 9. Хөрөнгө оруулагчдын арилжаанд эзлэх хувь**



Эх сурвалж: “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК

#### 4.1. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үзүүлэлтүүд

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид 318 ХК-ийн 1.4 их наяд төгрөгийн зах зээлийн үнэлгээ бүхий 22.2 тэрбум ширхэг үнэт цаас хадгалагдаж байгаагаас гадна 29 төрлийн 24.9 сая ширхэг компанийн бонд, 160 төрлийн 8.3 сая ширхэг Засгийн газрын бонд тус тус бүртгэлтэй байна. Үүнээс 24 төрлийн 24.5 сая ширхэг компанийн бонд, 83 төрлийн 2.95

сая ширхэг Засгийн газрын бонд биржийн бус зах зээл буюу хаалттай хэлбэрээр бүртгэгдсэн байна.

Мөн “Хөдөө аж ахуйн давхар даатгал” хаалттай ХК-ийн 150.0 сая ширхэг хувьцаа, “Ард санхүүгийн нэгдэл” хаалттай ХК-ийн 22.7 сая ширхэг хувьцаа, “Апи ресурс” хаалттай ХК-ийн 2.2 сая ширхэг хувьцаа, “Монгол базальт” хаалттай ХК-ийн 39.4 сая ширхэг хувьцаа, “Хөрөнгө оруулагч үндэстэн” хаалттай ХК-ийн 10 сая ширхэг хувьцаа төвлөрсөн хадгаламжид тус тус бүртгэлтэй байна. Нийт Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэлтэй 318 ХК-ийн 22,245,285,497 ширхэг үнэт цаасны 12.67 хувийг төрийн өмчийн оролцоотой компанийн, 0.13 хувийг орон нутгийн оролцоотой компанийн, 87.2 хувийг төрийн мэдлийн бус буюу хувийн компанийн хувьцаа тус тус бүрдүүлж байна.

--oOo--